

“ГАДААД ЗАСГУУДЫН УГ ЭХ” ХЭМЭЭХ БҮТЭЭЛИЙН ТУХАЙ

Э.ЖИГМЭДДОРЖ

XVII-XX зууны эхэн үеийн Монголын түүхэнд холбогдох архивын баримт, сурвалж бичиг дэлхийн олон орны архив, номын сан, музей зэрэг газарт буйг эрдэмтэд судлан шинжилсээр байна. Тухайн цагийн түүхийг судлах олон хэлний сурвалжийн дотор манж бичгийн дурсгал чухал нөлөөтэй.

Франц Улсын үндэсний номын санд XVII-XVIII зууны үеийн Халх дөрвөн аймаг, Хөх нуур, Алшаа, Эзнэйн хаад, ноёд болон Хами, Турфан, Тангадын ноёдын уг эхийг бичсэн манж үсгийн 6 дэвтэр цэс буй. Уг цэсийн талаарх товч мэдээлэл 1970-аад оны сүүлээр нийтийн хүртээл болсон хэдий ч тухайлсан судалгаа хийгээгүй өнөөг хүрсэн юм.

Парис хотод 1979 онд хэвлэгдсэн Францын үндэсний номын сангийн манж номын гарчигт *Etudes sur les tribus mongoles de la Chine* хэмээх нэрээр 6 дэвтэр тус бүрийн нэр, цаасны хэмжээ, хуудасны тоо зэргийг танилцуулсан¹ бол 2015 онд цэсийн гэрэл зургийн хуулбарыг цахим сүлжээнд нээлттэй байршуулжээ².

Доктор (Ph.D), дэд профессор Боржигин Багана Франц Улсын үндэсний номын сангийн цахим сүлжээнд буй манж үсгийн 6 дэвтэр цэсийн гэрэл зургийн хуулбарт тулгуурлан тус сурвалжийг судлан шинжилж, *Гадаад засгуудын уг эх*³ нэрээр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод нийтлүүлэв.

Гадаад засгуудын уг эх бүтээл нь удиртгал, монгол орчуулга, эрдэм шинжилгээний тайлбар, латин үсгийн галиг, тайлбар, ном зүй, гэрэл зургийн хуулбар бүхий 560 талаас бүрдэнэ. Удиртгал хэсэгт 6 дэвтэр тус бүрийн гарчиг, эх бичгийн онцлог, агуулга, цэсийг үйлдсэн он цаг, сурвалжийн үнэ цэнэ, ач холбогдлын талаар эш баримттай өгүүлжээ.

Эрдэм шинжилгээний тайлбар хэсэгт 6 дэвтэр манж цэст буй язгууртан ноёдын талаарх мэдээ баримтыг бусад сурвалж бичигтэй харьцуулан үзэж, намтар, үйл хэргийг дэлгэрүүлэн өгүүлсний зэрэгцээ түүхэн хэрэг явдал, газар ус, хүний нэр зэргийг нарийн нягт тайлбарлан бичсэн байна.

Энэхүү манж цэст Монгол, Хотон, Тангад бүгд 128 язгууртны зэрэг, хэргэм өргөмжилсөн болон залгамжилсан уг эхийг тодорхойлон бичжээ. Зургаан дэвтрийн тус бүрийн гарчигт цөм “засгуудын уг эх” гэж байгаа боловч хошуу захирагч засаг ноёд, шавь захирсан засгийн тамга бүхий хутагт болон засаг

¹ Jeanne-Marie Puyraimond. *Catalogue du Fonds Mandchou*, Paris: Bibliotheque Nationale, 1979, 76-77.

² <http://gallica.bnf.fr/ark:/12148/btv1b52505790f/f5.image.r=mandchou>

³ *Гадаад засгуудын уг эх*. Удиртгал, монгол орчуулга, галиг, тайлбар үйлдсэн Боржигин Багана. Улаанбаатар: Соёмбо принтинг, 2024. 560 тал

тэргүүн зэргийн тайжийн зэргийн ноён, засгийн албан тушаал бүхий дархан гэх дөрвөн төрлийн хүмүүс буй аж.

Сайхь судлаач *Гадаад засгуудын уг эх*-д тэмдэглэсэн хаад, ноёдын зэрэг, хэргэм өргөмжилсөн болон залгамжилсан огноог үндэслэн тус 6 дэвтэр цэсийг Манжийн Тэнгэрийн Тэтгэсний 3-р он буюу нийтийн он тооллын 1738 онд зохиогдсон (тал 18) хэмээн үзсэн нь үндэстэй байна.

XVII-XX зууны эхэн үед монгол, манж үсгээр ноёд, язгууртан нарын уг эх арвин бичигдсэн нь лавтай боловч үлдэж хоцорсон зүйл нэн ховор юм. Эдүгээ судалгааны хүрээнд мэдэгдэж байгаагаар Монгол Улсын Үндэсний Төв Архивт буй *Халхын Түшээт хааны аймгийн ноёдын уг эх*⁴ (монгол бичгээр), *Халхын Сайн ноён аймгийн ноёд, хутагт, хувилгаадын уг эх*⁵ (монгол бичгээр), *БНХАУ-ын Үндэсний номын санд буй Халхын Засагт хаан аймгийн ноёдын үе залгамжийн зураг*⁶ (монгол бичгээр) тус бүр 1901 онд бичигдсэн, *Цахарт хавсаргасан Хошууд ноёдын уг эх үе залгамж*⁷ (манж үсгээр) 1902 он, *Хорчины ноёдын уг эх* (монгол бичгээр) 1904 онд бичигджээ.

Иймд өгүүлэн бүхий 6 дэвтэр манж цэс он цагийн хувьд эдгээрээс урьд зохиогдсон тул сурвалжийн ач холбогдол энэ хэмжээгээр өндөр байх бололцоотой юм.

Энэхүү *Гадаад засгуудын уг эх*-д XVII-XVIII зууны Монголын түүхэнд холбогдох бусад сурвалж бичигт төдий л тохиолдохгүй мэдээ баримт цөөнгүй байна. Үүнд,

- Манжийн үеийн Халхын дөрвөн аймгийн чуулган нийлэх газар буюу тэр газрын нэрээр тодорхойлогдсон чуулганы нэр хувирч өөрчлөгдөж байсныг тус сурвалжийн мэдээ гэрчилж байна. Энэ тухай судлаач Боржигин Багана бусад сурвалжтай харьцуулан тодорхой өгүүлсэн буй (номын 28-29 дүгээр талд үзнэ үү).
- Халхын Сэцэн хааны дүү Санжжав Улсад туслагч гүн болсон тухай *Илтгэл шастир*-т “Энх-Амгалангийн 56-р (1717) он зарлигаар түүний тэмээг захирах ба ам зөөх гавьяаг сайшааж Улсад туслагч гүн өргөмжлөв” гэж зөвхөн гавьяаг тэмдэглэсэн бол манж бичгийн 6 дэвтэр цэс-т “*Хөнгий Завханы цэргийн газар хүртэл цэргийн хүнс зөөвөрлөж*” хэмээн газар усны нэр, үйл явдал зэргийг тодруулсан байна.
- Халхын Сэцэн хаан аймгийн засаг тэргүүн зэрэг тайж Шагдаржав бээр “Далай ламыг Зууд хүргэхэд өглөгийн эзэн болж их цэргийн хамт Зууд хүрч Далай ламыг ширээнд суулгаж их үйлийг бүтээсэн хэмээн Найралт

⁴ *Халхын Түшээт хан аймгийн засаг ноёдын уг эх*. Улаанбаатар: “Удам соёл” ХХК, 2021. 774 тал.

⁵ *Халхын Сайн ноён аймгийн ноёд, хутагт, хувилгаадын уг эх*. Улаанбаатар: “Удам соёл” ХХК, 2023. 821 тал.

⁶ *Qalq-a-yin jasytu qan ayimay-un wang güng-nar-ün ger-ün üy-e-yin bičimel*, Soyoltu erkilen nayirayuluysan, *Erten-ü monggol sudur bičig-ün degejis*, 15-duyaar boti, öbör mongyol-un arad-un keblel-ün qoriy-a, 2020; *Халхын Засагт хан аймгийн ноёдын уг эх*. Улаанбаатар, : “Удам соёл” ХХК, 2024. 400 тал.

⁷ Ulağanbayana. Amerika ulus-un Harvard-Yanjing-un nom-un sang-du bayiy-a manju “köbegetü sir-a-yin čaqar qosiyun-du qabsurğaysan qoşud güng taiji-nar-un ergümjilekü jarli-y-i qayuluysan uy eki, ger-ün uy-un bičig. *Kele ba orčiyul-y-a*. 2014 on-u 3 duyar quyučay-a, 68-71 duyar tal-a.

Төвийн 1-р (1723) онд Улсад туслагч гүн болгов” хэмээн тэмдэглэсэн нь Манжийн их цэрэг VII Далай ламыг Зууд хүргэж ширээнд суулгахад Халх, Хөх нуур, Алшаагийн язгууртан нар өглөгийн эзний хувиар дагалдан явахад тус ноён оролцсныг харуулна. Манж, монгол архивын баримт, түвд намтар зэрэгт Шагдаржавын нэрийг дурьдаагүй бөгөөд хожмын *Илтгэл шастир*-т товч өгүүлсэн байдаг нь энэ мэдээ ховор чухаг гэдгийг илтгэнэ.

- “*Илтгэл шастир*-т Халхын Сайн ноён аймгийн дээд өвөг Данзан ламын ач хөвгүүн Ванчигийн төрөл гарлыг тодорхойлсон боловч түүнийг “бичгийн яаманд явах” албан тушаалтай байсныг бичээгүй. Өгүүлэн буй цэст Ванчигийг “угтаа Халхын баруун гарын бичгийн яаманд явах, Итгэл найрт Данзан ламын ач хөвгүүн” хэмээн тэмдэглэжээ. Энэ нь Халхын язгууртан ноёдын хүүхэд Бээжин сурч асан түүхийг судлах нэгэн чухал баримт болно.
- Хөх нуурын тайж Цэрэндондов (Манжийн төрөөс бэйл, бэйс хэргэм хүртсэн)-ийн хошууны бэйс хэргэмийг түүний үр болгон тэжээсэн хөвгүүн Халхын засаг тэргүүн зэргийн тайж Сэвдэн бошигтын дүү Дамба-д залгамжлуулсан тухай өгүүлжээ. Энэ бол Халх, Хөх нуурын ноёдын харилцаа, монгол язгууртан нарын өв өвлөх ёсны тухай сонирхолтой мэдээ аж.

Дээрх жишээ баримт нь XVII-XVIII зууны Монголын түүх, хаад, ноёдын намтар, Манжийн төрийн бодлого, үйл ажиллагааг гүнзгийрүүлэн судлахад ач холбогдолтой.

Өгүүлэн буй *Гадаад засгуудын уг эх*-д сурвалж бичгийн эндүү ташаа мэдээг залруулах, нягтлах баримт басхүү үзэгдэж байна. Тухайлбал, Халхын Засагт хаан аймгийн цэсийн Хотгойдын засаг төрийн бэйл Цэнгүнжавын уг эх-д “... түүний төрсөн хөвгүүн Бандийг мөнхүү засаг төрийн бэйл залгамжлан өргөмжлөв. Үгүй болсны хойно Найралт Төвийн 12-р онд түүний төрсөн хөвгүүн Цэнгүнжавыг мөнхүү засаг төрийн бэйл залгамжлан өргөмжлөв” гэжээ. Дайчин Улсын Шизун Хуандигийн магад хууль-ийн Найралт Төвийн 12-р оны намрын дунд сарын улаан луу өдөр (арван гурван, 1734 оны 9-р сарын 10) -ийн зүйлд тэмдэглэсэн нь: “Хотгойдын үгүй болсон засгийн төрийн бэйл Бандигийн хөвгүүн Цэнгүнжавт хэргэм залгамжлуулбай” гэжээ. Харин *Илтгэл шастир*-ын 63-р дэвтрийн Засаг төрийн бэйл Гэндэнгийн олдворын шастир-т тэмдэглэсэн нь: “гуравдугаар удаа залгамжилсан Банди. Бүүвэйн ахмад хөвгүүн, ... Тэнгэрийн Тэтгэсний 2-р [1737] онд үгүй болсны хойно түүний хөвгүүн Цэнгүнжавт залгамжлуулбай” гэжээ. Гурван сурвалжийн тэмдэглэлийг тулгаж үзэхэд, *Гадаад засгуудын уг эх* болон *Магад хууль*-ийн тэмдэглэл харилцан дүйж байгаа бол *Илтгэл шастир*-ын тэмдэглэл зөрүүтэй байна. Хэрэг дээрээ бусад манж, монгол баримтаас үзэхэд Хотгойд Цэнгүнжав Найралт Төвийн 12-р (1734) онд зэрэг залгамжилсан юм. *Илтгэл шастир* энэ явдал дээр ташаарсан” (тал 32),

Халхын Сэцэн хаан аймгийн туслагч тайж байсан Туулай хэрхэн хошууны засаг, тэргүүн зэргийн тайж болсон тухай *“Энх-Амгалангийн 50-р онд Туулай нар биеэ Сэцэн хаан асан Бабуугийн үр ач нар, тэдний 600 гаруй эрсийг хошуу сум зохиогоод ондоо засаг болгох ажааму хэмээн гүйн айлтгасан”* Туулай ганцаар биш, өөр бас ах дүү нар лугаа хамтаар Сэцэн хааны хошуунаас салах эрмэлзэл илэрхийлснээр бичсэн байна. Харин *Илтгэл шастир*-ын холбогдох хэсэгт ганц Туулайг дурдан өгүүлсэн буй. *Илтгэл шастир* зарим түүхэн мэдээг балархай болгосон байна” (тал 69),

Хотогойдын засаг төрийн бэйл Сүнжинсэнгэ-гийн хэргэм залгамжилсан талаарх Манжийн магад хууль, Илтгэл шастир зэрэг албан түүхийн мэдээ зөрүүтэй байгааг нягтлах боломжийг энэхүү цэс олгож буй. Энэ талаар судлаач Багана *“Манжийн ёсонд ноёд өөрөө хөвгүүн байхгүй бол үрчилсэн хөвгүүнд нь зэрэг залгамжлуулах тохилдолд зэргийг уг хэвээр нь зулгамжлуулах бус, харин тодорхой хэмжээгээр бууруулаад залгамжлуулдаг. Сүнжинсэнгэ Гэндэнгийн төрсөн хөвгүүн мөн болохоор Гэндэнгийн зэргийг уг хэвээр нь залгамжлах нөхцөл боломж бүрэн төгөлдөр буй юм. Гэтэл Бүүвэй бол Гэндэнгийн төрсөн хөвгүүн биш учраас зэргийг бууруулж байгаад залгамжлуулах нь ойлгомжтой хэрэг. Бидний өгүүлэн бүхий манж цэст буй мэдээ Дайчин гүрний Дотоод яамны монгол бичгийн гэрийн данс-тай дүйж байгаа нь бас олзуурхууштай”* (тал 79) хэмээсэн жишээг дурьдаж болно.

Гадаад засгуудын уг эх-д түүхийн сурвалж бичигт тэр бүр бичдэггүй хувь хүний зан төлөвийн талаарх мэдээ буйг хэлэхгүй өнгөрч боломгүй. Тухайлбал,

- Халхын Сэцэн хаан Цэвдэнбайнжурын тухайд *“Найралт Төвийн 6-р онд Сэцэн хааны цолыг төрсөн хөвгүүн Цэвдэнбайнжүрт залгамжлуулав. Цэвдэнбайнжүр ноомой буурай, доорх ардаа захирч чадахгүй болохоор хааны цолыг нь эвдээд Найралт Төвийн 11-р [1733] онд өвөг авга төрийн жүн ван Чойжавт Сэцэн хааны цолыг залгамжлуулав”*,
- Халхын Сэцэн хаан аймгийн засаг, тэргүүн зэргийн тайж Дамиранжавын тухайд *“Дамринжав тэнэг бөгөөд согтуу, засаг хэргийг шийтгэн үл чадах тул засгаас байлгаад Найралт Төвийн 11-р [1733] онд түүний төрсөн хөвгүүн Ванчигдаржаа-г засаг тэргүүн зэргийн тайж тавив”*,
- Өвгөн Сэцэн хаан Норовын ач хөвгүүн Цэвээндоржийн тухайд *“Цэвээндорж тэнэг болхи, засаг хэргийг шийтгэн үл чадах тул засгаас байлгаад Найралт Төвийн 11-р [1733] онд түүний төрсөн дүү Ванжил-ийг засаг тэргүүн зэргийн тайж тавив”*,
- Халхын Сэцэн хаан аймгийн засаг тэргүүн зэрэг тайж Таван *“...доорх ардаа захиран чадахгүй, худалдааны иргэдийн юмыг тоносон учирт засгаас байлгаад Найралт төвийн 13-р [1735] онд Тавангийн ахын хөвгүүн Чухал-ыг засаг тэргүүн зэргийн тайж тавив”*,
- Хөх нуурт суусан Халхын тайж засаг Гэндэнгийн тухай *“Гэндэн согтуу, тэрслүү, олон лугаа үл зохилдох учирт засгаас байлгаад, Гэндэн Халхын гүн Тонмогийн ойр төрлийн авга мөн болохоор Хөх нуураас нүүлгээд*

Тонмогийн хошуунд суулгав. Түүний оронд Тэнгэрийн Тэтгэсний 2-р [1737] онд Даишдондовыг засаг тэргүүн зэргийн тайж тавив”

хэмээн бичжээ.

Эдгээр мэдээ нь Халхын зарим язгууртан, ноёдын бодит байдлыг харуулсан бөгөөд нөгөө талаас төр түших хүмүүний үүрэг хариуцлага, зан чанар, чадвар ямар байх ёстойг сануулсан эдүгээ бодууштай зүйл болохыг хэлэх юун.

Судлаач Боржигин Багана бээр *Гадаад засгуудын уг эх*-д буй засаг ба засаг бус ноёд тус бүрийн мэдээг бусад сурвалж бичигтэй харьцуулан үзэж, намтар, үйл ажиллагаа, зарим түүхэн хэрэг явдлыг дэлгэрүүлэн өгүүлсэн нь судалгаанд чухал ач холбогдолтой юм. Үүнд, нэн тэргүүнд *Дайчин гүрний Дотоод яамны монгол бичгийн гэрийн данс, Зарлигаар Тогтоосон Гадаад Монгол, Хотон аймгийн ван гүнзүүдийн илтгэл шастир, Дайчин Улсын Шэнзу Хуандигийн Магад Хууль, Дайчин Улсын Гаузун Хуандигийн Магад Хууль, Дайчин улсын бүгд хууль, Халхын дөрвөн аймгийн ноёдын хүрдэн зураг* зэрэг сурвалжийн холбогдох мэдээ баримттай тулган нягталж, нарийн шинжлэн судалжээ. Энд зарим жишээг дурьдвал,

Халхын Сэцэн хаан аймгийн засаг төрийн жүн ван Намжилын тухайд “Намжил бол Өмхийн авга, угтаа Эрдэнэ тайж бүлгээ. Хойно Өөлдөд шахагдаад Манжид дагаар ирсэнд Эрдэнэ жонон болгов. Тэр үед Өмхий Сэцэн хаан Үзэмчиний захын гадна нутаглаж, Намжил түүнээс цааш нэг өдрийн газарт нутаглаж байв. Дүрвэж ирсэн олныг засахын тул Намжилыг засаг болгосон байна. Тэр үед Сэцэн хаан Өмхий нас бага байснаас хэрэг дээрээ Манжид дагаж орсны эхний хэдэн жилд Сэцэн хааны аймгийн хэргийг Намжил ахалж байсан юм. *Илтгэл шастир*-т Намжилийн зэрэг өргөмжилсөн ба нас барсан он жил нь байхаас бус сар, өдөр нь байхгүй тул бид Манжийн хаадын магад хуулиас сар, өдрийг нь лавлан харах хэрэгтэй. *Дайчин Улсын Шэнзу Хуандигийн Магад Хууль*-ийн 151-р дэвтрийн Энх-Амгалангийн 30-р оны зуны дунд сарын шар хулгана өдөр /шинийн гурван, 1691.5.30/-ийн зүйлд Намжилийг төрийн жүн ван өргөмжлөв” (тал 57) гэсэн бол,

Халхын Сайн ноён аймгийн Улсад туслагч гүн Цэвдэнжавын талаар “Цэвдэнжав бол Цэрэнгийн хөвгүүн мөн. Өгүүлэн буй манж цэсийг бичсэн Тэнгэрийн Тэтгэсний 3-р оны үед Цэвдэнжав гүнгийн зэрэг өргөмжлөгдсөн боловч засаг биш тул өөр хошуу болсонгүй. Тэнгэрийн Тэтгэсний 17-р онд Цэвдэнжавыг тусгаар засаг болгоод, 21-р онд төрийн жүн ван өргөмжилж, 23-р онд чин ван болгон дэвшүүлсэн байна. 45-р онд чин вангаас бууруулаад жүн ван болгов. Цэвдэнжав Өөлд, Хасагийг авах тулаанд эрэмгийлэн явсан бөгөөд түүний хамгийн чухал нэг үйл ажиллагаа гэвэл Тэнгэрийн Тэтгэсний 27-р онд Далай ламын 8-р дүрийн гэгээнийг ширээнд залахад Цэвдэнжав Зууд одож хамаг монгол хаад, ноёдын төлөөлөл болж тэр их ёслолд оролцож билээ. Манжийн хаан Цэвдэнжавын эр баатар болон байлдааны гавьяаг сайшаан бусад олон зүтгэлтэн сайдын хамт биеийн хөрөг дүрслэн зураад тусгай зориулалтын газарт дурсгал болгон хадгалсан билээ. Тэр зураг 2017 оны үед ОХУ-ын Санкт-Петербург хот

дахь Эрмитаж музейн үзэсгэлэнд дэлгэгдэж байсан юм” (тал 105) гэх мэт олон жишээг дурьдаж болмуй.

Доктор (Ph.D) Багана тус бүтээлдээ судлаачид түүхийн сурвалжийг унших явцад эндүүрсэн цөөнгүй зүйлийг залруулжээ. Жишээлбэл, “Илтгэл шастирт Халхын Засагт хаан аймгийн Сэцэн засгийн хошууны засаг ноён Сэрэн Ахайг “Сарт голын газарт сууж” /*Sarta yol-un yaĭar-tur saĭju*/ гэж байгааг судлаачид тэр бичсэн ёсоор нь Сарт гол гэх газраар ойлгосон байна. Гэтэл Халхын хаад ноёдын хүрдэн зурагт Сэрэнгийн нэгэн хошууг Сартуул засаг гэсэн байна. Сартуул гэгч ялангуяа Төв Азиас гаралтай аймаг ястан. Сэрэн Ахайн нэгэн угсаа Сартуул дээр сууснаар нь Халхын дотроо Сартуул засаг гэж алдаршсан юм. Монгол сурвалж бичигт хаад ноёд аль нэг аймаг улсыг ноён эзэмшихийг тэр аймаг улс дээр суув гэдэг. Жишээ нь, Сэрэн Ахай Сартуул дээр суув гэх мэт. Иймэрхүү өгүүлэмжийг манж хэлэнд буюу хятад хэлэнд хөрвүүлэхэд Сартуул нь аймаг улс биш, харин газрын нэр болж мэдрэгддэг. Үүний дээр *Илтгэл шастир*-ын монгол эхэд *Sartaŋul* гэх бичлэгийг *Sarta ŋul* гэж хоёр салгаж бичихээр нь хүмүүс *ŋul*-ыг гол гэж уншаад бүхэлд нь Сарт гэсэн голын нэр болгож эндүүрсэн байна. Ерөөсөө Халхын Засагт хааны улсуудын нутаглан суудаг Хангайн нурууны баруун биеийн газарт Сарт гэсэн гол байхгүй тул газар зүйн талаас бас уг ташаарлыг нотолж байгаа юм. *Sartaŋul*-ыг Сарт гол болгосон эндүүрэл бол бичгийн баримт монгол бичгээс манж бичигт, манж бичгээс хятад бичигт, дахиад хятад бичгээс манж бичигт, манж бичгээс монгол бичигт гэхчлэн нэг бүтэн дугуй татан орчуулагдах явцад монгол, манж, хятад гурван ард түмний хэл соёлын мэдрэмжийн зөрүүнээс урган гарсан зүйл юм” (тал 81) гэжээ.

Судлаач Багана сурвалжийн тайлбар хэсэгт Манжийн төрөөс монголчуудын талаар явуулсан бодлогын цаад мөн чанар, хувиралт зэргийн талаар өөрийн байр суурийг илэрхийлсэн нь түүхийн судалгаанд анхаарч үзүүштэй санал байна. Тухайлбал,

-“*Илтгэл шастир*-т бас нэг зүйлийг тэмдэглэсэн нь, Энх-Амгалангийн 30-р онд Долоон нуурын чуулган дээр Соном-Ишжав бээр Пунцагравдан лугаа жонон цолыг булаалдсанд Манжийн хаан жонон цолыг орхиж ноён зэргээс гаргасан байна. Анх Сэцэн хааны улс дагаар ирсэнд Манжийн хаан Сэцэн хааны олон ноёдыг жонон болгон өргөмжилсөн билээ. Энэ нь тэр үед Манжийн хаан жонон гэх цолыг ноёдын зэрэглэлээс гаргаж хаях санаа байсангүйг харуулж буй. Жонон цолыг Долоон нуурын чуулган дээр ноёдын зиндаанаас гаргаж хаясан явдал хэдийгээр Манжийн хаан Өвөр дөчин есийн төрийн зэрэглэлээр Халхын төрийг дахин цэгцлэх утгатай байсан боловч уг явдлын өнгөн дээрх эх үүсвэр нь монгол ноёдын зэрэг цол булаалдаж байсантай холбоотой юм байна” (тал 85),

-“Хөх Нуурын монголчууд ихэнх нь Хошууд байснаас гадна, Өөлд, Хойд, Торгууд, Халх зэргийн хүмүүс бас байсан аж. Ялангуяа Хөх нуурт бусад монгол аймаг чуулганд байдаггүй ердөө засаг гэх олон тайж нарын нийт дундын засаг 2 байгуулагдсан нь их л онцлог зүйл байгаа билээ. Энэхүү нийт дундын засаг гэгч ирэлтийн хувьд Манжийн найман хошуун доторх ердөө сум гэгчээс үлгэр авч

үүссэн боловч хэрэг дээрээ эртний нүүдэлчдийн өнө эртний уламжлалтай засаг захиргааны системийн нэгэн хувилбар байсан юм” (тал 128),

–“Засаг тэргүүн зэргийн дархан: засаг ба дархан хоёр цөм монгол уламжлалын албан тушаал болон гавьяаны цол бүлгээ. Гэхдээ энэ хоёрыг нэгтгэн хэрэгэлэсэн явдал монгол аймаг хошуудад гарсангүй, харин Хамигийн Хотонгийн ахлагч хүний бие дээр буй болсон байна. Энэ нь Манжийн хаад монгол уламжлалын засаглалын өв буюу элементүүдийг нийлүүлэх, салгах гэх зэргийн олон янзаар улируулан ашиглаж байсныг харуулна” (тал 137) хэмээжээ.

Гадаад засгуудын уг-д түүхийн чухал мэдээ баримт байгаагийн зэрэгцээ нягтлууштай, эндүү ташаа байж магадгүй зүйл буйг судлаач Багана бээр гярхай ажиглаж, тухай бүрт тайлбар хийсэн байна. Тухайлбал, “Халхын засаг тэргүүн зэргийн тайж Хамар дайчинг урьдаар тэргүүн зэрэг тайж болгоод дараа нь засаг болгосон атал манж үсгийн цэст хоёр удаа болсон хэргийг нэг удаа болсон мэт өгүүлсэн байна” (тал 88), Хөх нуурын засаг Улсад туслагч гүн Лувсанцагааны талаар “Намжил Энх-Амгалангийн 42-р онд үгүй болсонд Лувсанцагаан залгамжилсан. Намжилийн үеэс төрийн бэйл өргөмжлөгдсөн байтал манж үсгийн цэст Лувсанцагаанаас эхэлж тооцсон” (тал 120) зэргийг дурьдаж болно. Энэ мэт жишээ нь түүхийн сурвалж бичгийг судлан шинжлэхэд нэн хянамгай хандахын ач холбогдлыг сануулж буй хэрэг амуй.

Судлаач Багана манж бичгийн 6 дэвтэр цэсийг монгол хэлэнд орчуулахдаа түүхэн зүтгэлтэн, улс, аймаг, газар усны нэр, цол, хэргэм зэргийг бусад сурвалж бичигтэй харгуулж, түүхийн төдийгүй хэл шинжлэлийн тайлбар зүүлт хийсэн байна. Жишээлбэл,

Элжигэн Халхын тухайд “*Илтгэл шастир*-т Бадам хатанбаатар Эржигэний газарт суужухуй /Erjigen-ü yaġar saġjuquī/ гэж буй. *Erjigen* гэгч монгол бичгийн *Eljigen*-ий ташаа бичлэг. *Eljigen* гэгч Халхын Илжгэн аймгийг хэлж буй. Бадам хатанбаатар “Эржигэний газарт суужухуй” гэгч уг нь Илжгэн гэх улсыг ноёлон суусан гэх утгатай “Илжгэн дээр суужухуй” гэсэн монгол өгүүлэмж байсан юм. Уг өгүүлэмж монгол→манж→хятад→манж→монгол гэхчлэн олон дахин орчуулагдах явцад хэл болон соёлын зөрүүнээс шалтгаалж аймаг, улс дээр суусан гэх санаа нь гажуудаад газар нутаг дээр суусан болж хувирчээ” (тал 86) гэсэн бол,

Халх хэмээх үгийг манж, хятад хэлэнд хэрхэн орчуулж ирсэн талаар “*kalkai*: Манжийн эрхшээл тогтож эхэлсэн 17 дугаар зууны эхэн үе гэхэд монгол хэлэнд *x*, *z* хоёр гийгүүлэгч дүйцэн тогтнох болоод байсан юм. Гэтэл манж хэлэнд *h*, *g*, *k* гэх гурван гийгүүлэгч дүйцэн байдаг нь хэвээр байжээ. Манж нар анх үсэг зохиоход монгол бичгийн *x*, *z* хоёр гийгүүлэгчийг тэмдэглэх үсгээр манж хэлнийхээ *h*, *g*, *k* гурван гийгүүлэгчийг тэмдэглэж байв. Хойно нь манж нар үсэгтээ өөрчлөлт оруулсны улмаар угын *h*, *g*, *k* гурван авиаг тэмдэглэх үсэгт дусал бинд нэмээд дүрсээрээ ялгарах *h*, *g*, *k* гурван үсэг буй болгосон байна. Энэ шинэ гурван үсгийн дотор *k* нь монгол бичгийн *x* хэмээн уншигдах *q(k)* үсэгтэй дүрс ижил болов. Манжийн үед монгол оноосон нэрийг монгол бичгээс манж бичигт хөрвүүлэхэд монгол хэлний *q(k)* үсгийг тэр хэвээр нь дусал бинд

нэмэхгүйгээр буулган бичих тохиолдол маш олон байжээ. Тэгэж буулган бичихэд монгол хэлний *x* хэмээн уншигдах *q(k)* үсэг хэлбэрээрээ манж бичигт ороход тэр нь мэнж хэлний *k* гийгүүлэгчтэй дүрс ижил болохоор зайлшгүй *k* болж дуудагддаг. Монгол бичгийн *qalq-a* гэх үг манж бичигт уг хэвээр ороод *kalk-a* буюу *kalka* хэмээн бичигдэхэд манж хэлний авианы зарчмаар *xalx* биш харин *kapka* болж дуудагдах болно. Энэ *kapka* нь цааш хятад хэлэнд хөрвүүлэгдэхэд *k* гийгүүлэгч бүхий хятад үсгээр галиглагдаж *ka er ka* (喀尔喀) болдог байна. Монголын бусад аймаг угсааны нэр тухайлбал *хорчин*, *харчин* бас яг иймэрхүү замаар манж бичигт *korcin*, *karacin* болж үгийн эхний *x* нь *k* болж хувираад дахин манж хэлнээс хятад хэлэнд хөрвүүлэгдэхэд тус тус *ke er qin* (科尔沁), *ka la qin* (喀喇沁) гэх зэргээр *k* гийгүүлэгч эхтэй үсгүүдээр галиглагдсан байна.

Монгол нэр үгс манж бичигт ороход гарсан бас нэг авианы хувиралт гэвэл үеийн сүүлд орсон *l* гийгүүлэгчийн дуудлага хувирсан явдал болно. Монгол хэлний *l* гийгүүлэгч үеийн эхэн дунд адаг хаана байсан ч нэгэн адиларр *l* гэж дуудагдана. Гэтэл манж хэлний *l* гийгүүлэгч үеийн эхэнд *l* гэж дуудагдах нь монгол хэлнийхтэй ижил боловч үеийн адагт ороход дуудлага нь хувираад хэлний үзүүр дээш өндийх гийгүүлэгч болдог. Жишээ нь англи хэлний *air* гэх үгийн сүүлийн *r* гийгүүлэгчтэй төсөрхүү авиалагдана. Хятад хэлэнд иймэрхүү авиа байдаг бөгөөд тэр авиаг *er* (二、尔、而、儿、耳) гэх зэргийн нилээн хэдэн үсгээр тэмдэглэдэг. Манж хэлний үеийн адагт орсон *l* гийгүүлэгчийг мөн тэдгээр *er* гэх дуудлагатай хятад үсгээр галигладаг. Энэ шалтгаанаар *qalq-a* гэх нэр манж хэлэнд *kalka* гэж бичигдсэн бөгөөд *kapka* лугаа төсөрхүү авиалагдах учраас хятад хэлэнд хөрвүүлэхэд дундах *l* гийгүүлэгчийг *er* (尔) гэх үсгээр галиглаад бүхэлд нь *ka er ka* (喀尔喀) гэж бичих болсон байна” (тал 145),

Эрдэнэ зуугийн талаар “*erdeni juo*: монгол бичигт *juo*, *juu* хоёрын дүрс ижил байсныг манж бичигт цөм жоо гэж бичдэг байна. Манж бичгийн тэр журмаас хятад хэлэнд *zhao* (召) гэж галиглан бичих зуршил тогтсон байна” (тал 146),

Хэрлэн гэдэг үгийн тухайд “*kerulun*: монгол бичигт *kerülün* гэж бичдгийг манж бичигт тэр хэвээр нь буулган аваад түүнийгээ манж хэлний авианы зарчмаар дуудахад уг нэрийн эхний авиа *x* биш *k* болж хувирдаг. Энэ манж хэлний дуудлага цааш хятад хэлэнд нөлөөлж хятадаар *ke lu lun* (克鲁伦) гэдэг болжээ” (тал 152) хэмээн ул суурьтай тайлбарлажээ.

Түүхэн зүтгэлтний нэр, цолын тухайд нэг жишээ татвал, “Халхын Сайн ноён аймгийн засаг хошой чин ван, эфү, Шалгарсан баатар Цэрэнгийн тухайд “Цэрэнгийн баатар цолыг манжаар *colgoroko baturu* гэхэд монголоор хэдэн янзаар орчуулдаг, тухайлбал *Илтгэл шастир*-т Шалгарсан баатар гэхэд Манжийн үеийн зарим архивт Тасархай баатар гэсэн байдаг. Бид энд *Илтгэл шастир*-ын ёсоор Шалгарсан баатар гэж монголчилсон юм” (тал 94) гэж бичсэн байна.

Гадаад засгуудын уг эх бүтээлийн монгол орчуулга, эрдэм шинжилгээний тайлбар хэсэгт зарим ноёд, тайж нарын түүх намтрыг чухас төдий бичсэн, нийт үгийн хэлхээс дагалдуулаагүй зэрэг зүйл ажиглагдаж буй хэдий ч эдгээр нь тус номын үнэ цэнийг бууруулахгүй юм.

Доктор (Ph.D) Боржигин Багана тус бүтээлдээ *Гадаад засгуудын уг эх*-ийн латин үсгийн бүрэн галигыг хийсний зэрэгцээ гэрэл зургийн хуулбарыг хавсаргасан нь цаашдын судалгаанд чухал ач холбогдолтой болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Дээр дурьдсан зүйлүүдийг хураангуйлбал, судлаач Боржигин Баганы хэвлүүлсэн “*Гадаад засгуудын уг*” бол зөвхөн орчуулга бус түүхийн сурвалж бичиг судлалын цогц судалгааны бүтээл болжээ. Өөрөөр хэлбэл, “*Гадаад засгуудын уг*” хэмээх бүтээл нь түүхийн сурвалж бичиг судлалын сонгодог бүтээлүүдийн уламжлалыг хадгалсан эрдэм шинжилгээний үнэ цэнэтэй бүтээл мөн хэмээн үзэж болно.